



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/140

Эмээлтөлгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Монгол Улсын “Ургамал хамгааллын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумд микробиологийн аргаар үлийн цагаан Оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулж явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Ганзориг	(Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Д.Доржпагма	(Нягтлан бодогч)
	Т.Ариунтуул	(Газрын даамал)
	Ж.Сүхбаатар	(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Ц.Ганхуяг	(Жолооч)
	Багийн Засаг дарга нар	
	Байгаль хамгаалагч нар	

Нарийн бичгийн дарга: Б.Лхам-Осор (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршоо хариуцсан мэргэжилтэн)

2.Дээрх ажлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган, ажлын явцад байнгын хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлэн, ажлын хэрэгжилт үр дүнг сумын Засаг даргад мэдээлж, мэдээ, тайланг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Ганзориг), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршоо хариуцсан мэргэжилтэн (Б.Лхам-Осор), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ж.Сүхбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Үлийн цагаан оготной тэмцэх ажилд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын төсвөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн (Н.Эрдэнэ-Очир), нягтлан бодогч (Д.Баттөр) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХЖАРГАЛ